

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САН

Д/д	Үзмэрийн нэр	Хувийн дугаар	Тоо ширхэг	Хэмжээ	УБМС-ийн дугаар RCH (программын)	Судлагдсан сурталчлагдсан байдал	Саналын үндэслэл
1	Элдэв зүйлийн эмийн нэр тодотгосон бичиг	24/83	1 /118 хуудас/	Цаасны хэмжээ: 39.5x54.7 см бичвэрийн хэмжээ: 31.4x45.6 см, зузаан 1.8 см, жин 2965 гр.	1119TNC00173	1.Судар бичгийн алтан сан.- УБ., 2013.- 102х. 2.Монгол Улсын Үндэсний Номын сангийн эрдэнэсийн сан.-УБ., 2017.-166х. 3.Үндэсний бичиг соёлын өв.-УБ., 2017.- 212х. 4.Монгол Улсын Үндэсний Номын сан дахь монгол бичгийн өв.- УБ., 2024.- 220х.	<p>Элдэв зүйлийн эмийн нэр тодотгосон бичиг хэмээх энэхүү номыг 1847 онд Хорь буриадын Худай овгийн увш Ванчүг хэмээх хүн зохиожээ. Уг ном агуулгын тухайд эмийн зүйлийг ангилан ялгаж, эмийн зүйл тус бүрийн нэрсийг төвөд болон уйгуржин монгол бичгээр бичсэнээр эхэлдэг. Үүнд эрдэнийн эмийн зүйл 10 (алт, мөнгө, шүр г.м), чулуун эмийн зүйл 38 (гантиг, соронзон, шунх г.м), шороон эмийн зүйл 11 (алтан элс, хужир г.м), модон эмийн зүйл 10 (гавар, зандан г.м), шимийн эмийн зүйл 3, тан эмийн зүйл 13, өвсөн эмийн аймаг 119, амьтнаас 13 зүйлээр 107 гээд нийт 300 гаруй эмийн зүйлийг хамруулан бичсэн байдаг.</p> <p>Дараагийн хэсэгт эмийн зүйлийн зургийг зурж, тэдгээрийн шинж чанар, хятад ба орос нэршлийг бичиж өгснөөс гадна эмчлэгч болон эмчлүүлэгчдэд дөхөм болгохын тулд тухайн эмийг хаанаас хэдэн төгрөг хэдэн мөнгөөр олж болох тухай ч дурддаг.</p> <p>Мөн уг номд эмийн зүйлийн талаар өгүүлснээс гадна хануур (ханах цэг, ханах үед гарах цусны өнгөөр өвчнийг шинжлэх тухай), төөнүүр хийх (төөнүүр хийх цэг, арга, төөнүүр тавьсны ач тус), өвчин эмчлэх арга зэргийг монгол бичиг болон төвөд хэлээр хослуулан бичиж зургаар тайлбарласан нь уншигч, судлаач, анагаах ухааныг сонирхон суралцагчдад маш ойлгомжтой болсон уламжлалт эмчилгээний чухал сурвалж юм.</p> <p>Элдэв зүйлийн эмийн нэр тодотгосон бичиг хэмээх энэхүү ном нь ганц хувь гар бичмэл бөгөөд</p>

							<p>эх хувиараа хадгалагдаж буй тул 2.1.1 дэх шалгуурыг хангаж буй юм.</p> <p>уламжлалт анагаах ухааны ач холбогдолтой төдийгүй хүний биеийн бүтэц судлал, уламжлалт анагаах ухааны эм зүй судлал, эмийн нэршил судлалд онцгой байр эзлэхүйц өв болно. Өөрөөр хэлбэл, энэхүү ном нь анагаах ухаан судлал болон эм зүй судлалын тухай онолын болон практикийн өргөн мэдлэгийг агуулснаараа анагаах ухааны чухал хэрэглэгдэхүүн болох тул 2.1.2 болон 2.1.3 дахь шалгуурыг хангаж буй юм.</p> <p>Онолын ач холбогдол: Эмийн зүйлийн хятад, орос, монгол нэршил болон анагаах ухаан, тэр дундаа уламжлалт анагаах ухааны тухай онолын мэдлэгийг хүмүүст цэгцтэй олгох;</p> <p>Практик ач холбогдол: XIX зууны үеийн эмийн ургамлын зах зээл ямар байдалтай байсан, хэдэн төгрөг байсан гэх мэтийг өнөөгийн бидэнд таниулахаас гадна мөн уламжлалт анагаах ухааны хануур төөнүүр хийх, аливаа өвчнийг эмчлэх тухай үзүүлснээрээ практик ач холбогдолтой юм.</p>
2	Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг	24/79-1 24/79-2 24/79-3 24/79-4	4 /боть/	Цаасны хэмжээ: 21.1x33.6 см бичвэрийн хэмжээ: 19.5x24.1 см, зузаан 1.0 см, жин 500 гр.	1119ТНС00182 1119ТНС00183 1119ТНС00184 1119ТНС00185	1. “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг”, УБ., 164х, 1972. 2. Ш.Болд “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг”, УБ., 724х, 2022.	1692 онд Манжийн эзэн хаан хумхаа буюу чичрэг хэмээх өвчнөөр өвдсөн ба тэр үеэс эхлэн Европын анагаах ухааныг сонирхон судалж эхэлсэн гэдэг. Ийнхүү тэрбээр Христосын шашны элч Жоаким Бүветэд анатомийн тухай анагаах ухааны бүтээл бэлтгэхийг тушаажээ. Бүвет анатомийн ном бичих явцдаа тусгай лекц бэлтгэн Энх-Амгалан хаанд хичээл зааж байсан бөгөөд Франц руу явах болсны улмаас анатомийн ном бүтээх ажил түр зогссон учир 1698 онд Хятадад ирсэн Доминик Пареннин хэмээх өөр нэг элч уг ажлыг үргэлжлүүлэн дуусгасан байна. Уг бүтээл дуусмагц Бээжин хот, Нийслэлээс гаднах Цэнгэлдэх ордон, Манжийн хааны өвөг дээдсийн

						<p>нутаг Жихолд тус бүр 1 хувь нийт 3 хуулбарыг гараар хуулж хадгалжээ. Харин Паренин нэгэн тусгай хуулбарыг гараар бичиж Парис дахь ШУА-д илгээсэн нь Манж анатоми хэмээн алдаршсан бөгөөд тэрхүү хэмээх номын манж гар бичмэл эхээс монгол хэлээр орчуулан 4 боть болгон Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг хэмээн нэрлэжээ. Хожмоо уг номыг Судар бичгийн хүрээлэнгийн анхны дарга О.Жамьян гүн хулсан үзгээр хуулан бичсэн бөгөөд зургийг тухайн үед Судар бичгийн хүрээлэнд ажиллаж байсан Зөвлөлтийн мэргэжилтэн В.И.Лисовский гэрэлтдэг цааснаа хуулан зуржээ.</p> <p>Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг хэмээх энэхүү ном нь Монголын Манба дацангуудад үздэг хүний биеийн бүтэц зүйн сурах бичиг, эрдэмтэн мэргэдийн судалгааны бүтээл байсан төдийгүй сургалт, эмнэл зүйд нэвтрүүлэх, дэлгэрүүлэн хөгжүүлэхэд гол баримтлал болж байжээ.</p> <p>Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг хэмээх энэхүү ном нь Д.Сүхбаатар жанжны багш хэмээн олноо алдаршсан бичгийн их хүмүүн О.Жамьян гүний хуулан бичсэн тэрхүү гар бичмэл МУҮНС-ийн сан хөмрөгт эх хувиараа хадгалагдаж буй тул 2.1.1 дэх шалгуурыг хангаж буй юм.</p> <p>Энэхүү ном нь Монголын уламжлалт анагаах ухааныг сонирхон судлах хэн бүхний хэрэглэх гарын авлага, судалгааны чухал эх хэрэглэгдэхүүн бөгөөд анагаах ухааны сургалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дацангууд сургалтандаа хэрэглэх чухал гарын авлага болж байсан тул Манба дацанд суралцдаг байсан суралцагчид өрнө болон дорнын анагаах ухааныг хослуулан</p>
--	--	--	--	--	--	---

							суралцаж байсны баримт болох учраас 2.1.2 болон 2.1.3 дахь шалгуурыг хангаж буй юм. “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг” хэмээх ном нь Өрнө ба Дорнын анагаах ухааны мэдлэг ойлголтыг хослуулсан анагаах ухааны чухал эх сурвалж төдийгүй хүний биеийн бүтэц, өвчин судлал, эмчилгээний арга, эм найрлага, анагаах арга заслын ач холбогдолтой нэр томъёог судлах суурь, шинжлэх ухааны олон салбарыг хамран багтаасан хосгүй ном юм.
3	Жалзэтэмбан Ганжуур	24/20	111 боть	Цаасны хэмжээ: 70.3x25.0 см бичвэрийн хэмжээ: 15.0x59.5 см, зузаан 13.0 см, жин 17800 гр.	1119THC00614	1.Мөнх-Отгон.Д. Жалзэтэмбан Ганжуурын нэгэн төвөд гарчгийн эх бичгийн судалгаа.- Магистрын ажил. УБ., 2014. 2.Мөнх-Отгон.Д. Жалзэ тэмбан Ганжуурын нэгэн төвөд гарчгийн тухайд. Төвөд судлал. №3. УБ., 2014. 3.Хүрэлбаатар Л. Судар шастирын билиг. УБ., 2002. 472х. 4.Bethlensvalfy G.A hand list of the Ulan-Bator manuscript of the Kanjur Rgyal-rtse Them-spangs-ma. Budapest., 1982.	Ганжуур гэдэг нь “Зарлигийн орчуулга” гэсэн утгатай төвөд үг бөгөөд бурхан багшийн зарлиг номлолыг гурвантаа хураан өгүүлснийг цэгцлэн багтаасан буддын шашны утга зохиолын их цоморлиг юм. Жалзэтэмбан Ганжуурын тухай Л.Хүрэлбаатар гуай “Судар шаштирын билиг” номдоо “...УТНС-ийн Төвөд хөмрөгт байгаа ховор чухал бөгөөд түүхэн хэрэг явдалд холбогдох Ганжуурын дурсгалуудын дотор ‘Жалзэ-Тэмбам’ хэмээх 111 боть, маш сайхан хичээнгүй нарийн үсэгтэй, бичмэл Ганжуур байгаа юм. Үүнийг Төвөдийн Бүдөн гэгээн мутраараа бичиж бүтээсэн хэмээн хуучдын үгэнд ярих боловч, харин төгсгөлийн үгэнд бичсэнээр бол уг Ганжуур нь Бүдөн гэгээний сайтар нарийвчлан нуталж, ариутган шүүсэн судрын эх болгож бүтээсэн тухай дурдсан байна. Энэ Ганжуурыг 1671 онд Төвөдийн газраас Халхын Өндөр гэгээнд залуулсанд ‘Халхад урьд гараагүй гайхамшиг тансаг болов’ хэмээн төвөд сурвалжуудад онцлон тэмдэглэжээ. Жалзэ-тэмбам хэмээх төвөд үгийг хуучдын үгэнд ‘Хааны оройн чимэг, тэргүүн шүтээн, босгоор ч гаргаж үл болох нандин судар шүтээн’ гэх боловч, утгаа Ганжуурын хамгийн мадаггүй, дээд зэргээр шалган

						<p>байцааж, зөв эхийн гэрч тэмдэг болгосон бичмэл Ганжуур юм. Энэ бол Ганжуурын судлалд зөв эхийг байцаан тогтоох гол сурвалж болж буйгаараа, өнөө хэр Төвөдөд өөрт нь байхгүй эрхмийн эрхэм нандин болно” хэмээн бичсэн байдаг.¹</p> <p>Уг Ганжуурыг бүтээж дуусаад Төвөдийн номын хаан Ванчин Содномравданд өргөсөнд тэр хаан бээр Ганжуурын боть нэг бүрт алт, мөнгө, есөн эрдэнэ алаглуулан шигтгэсэн зузаан мөнгөн хуй хийлгэсэн байна. Тэгээд энэхүү судрыг I Ванчин богд Лувсанчойжижалцан, V Далай лам Агваанлуvsанжамц хоёр хэлэлцэн өөрийн дотно шавь Өндөр гэгээн Занабазарыг /1635-1723/ Лхаст очиж мөргөх үеэр нь 1671 онд бэлэглэсэн гэдэг. Гэтэл төвөдүүд Жалзэтэмбан Ганжуурыг Өндөр гэгээнд өгөх гэлээ хэмээн дургүйцээд зандан хавтас, мөнгөн хуйг нь авч үлдээд ачуулсан төдийгүй араас нь цэрэглэн ирсэн гэдэг. Үүнийг Өндөр гэгээн рид хувилгаанаар урьдчилж мэдээд номоо хавцалд нуугаад ганцаараа хүлээж байж. Тэгээд Төвөдүүдийг ирэхэд “Жалзэ Тэмбан” хурдан өртөөгөөр явсан, одоо бараг Монголын хилд орсон гэж хэлээд аргалж авч үлдсэн түүхтэй.</p> <p>Жалзэтэмбан Ганжуур судрын гурван боть нь дутуу. Түүний нэгийг нь Жаран Хашорын суварганы шүншигт, нэгийг нь сүмийн дээвэрт, нөгөөг нь Жанрайсигийн шүншигт хийсэн гэж ярилцдаг хэдий ч энэхүү мэдээ нь баттай бус юм. Учир нь төвөдүүд Монголд өгөх дургүй байсан тул ачуулахдаа аваад үлдсэн ч юм уу, аль эсвэл ачиж ирж байх замдаа алга болсон байж магадгүй юм.</p> <p>Жалзэтэмбан Ганжуур нь 1925 онд Богдын Цагаан ордноос хураагдаж, МУҮНС-ийн сан</p>
--	--	--	--	--	--	--

							<p>хөмрөгт ирсэн байна. Нийт 111 боть байхаас 110 нь Төвөд номын хөмрөгт, 1 боть нь Үнэт ховор номын хөмрөгт хадгалагдаж байна.</p> <p>Бүдөн гэгээний сайтар нарийвчлан нуталж ариутган шүүсэн, улмаар Төвөдийн Далай ламаас Өндөр гэгээн Занабазарт бэлэг болгон өргөсөн тэрхүү судар нь МУҮНС-ийн сан хөмрөгт эх хувиараа хадгалагдаж буй тул 2.1.1 дэх шалгуурыг хангаж буй юм.</p> <p>Түүнчлэн Жалзэтэмбан Ганжуур судар нь хэдийгээр төвөд хэлээр бичигдсэн төвөдүүдийн бүтээсэн дурсгал хэдий боловч Өндөр гэгээн Занабазар 1671 онд өөрийн биеэр Төвөдийн нутгаас залж авчирсан, түүнээс өмнө бүтээгдэн Монгол оронд даруй 350 гаруй жилийн турш хадгалагдаж буй Монголын түүхэнд холбогдох хосгүй өв мөн тул 2.1.2 болон 2.1.3 дахь шалгуурыг хангаж буй юм.</p> <p>Мөн Монгол орон болон бусад гадны орнуудад Ганжуур судрын модон бараар хэвлэгдсэн хувилбарууд түгээмэл байдаг боловч гар бичмэл хувилбар харьцангуй цөөхөн билээ. Жалзэтэмбан Ганжуур судар нь төвөд хэлээр бичигдсэн гар бичмэл эх төдийгүй Ганжуурын судлалд зөв эхийг байцаан тогтоох гол сурвалж болох тул 2.1.2 дахь шалгуурыг хангаж байна.</p>
4	Банзрагч	24/101	1 /174 хуудас/	Цаасны хэмжээ: 55.2x18.1 см бичвэрийн хэмжээ: 50.1x14.0 см, зузаан 5.5 см, жин 2500 гр.	1119ТНС00145	1.Мөнхсайхан С. Банзрагчийн монгол орчуулгын төгсгөлийн үгийн харьцуулсан судалгаа.- Диссертаци. УБ., 2004. 164х.	Банзрагч хэмээх судар нь хүн хэмээгчид тохиолддог ад тотгорыг арилгах тухай бурхан багшийн өгүүлсэн шашны утга агуулгатай гүн ухааны зохиол юм. Уг зохиол Их мянганыг машинд дарагч нэрт их хөлгөн судар, Их ухааны тарнисын хатан, Хутагт өөр өөр дагагч их ухааны тарнисын хатан, Их сэрүүн нэрт ой судар, Их нууц тарнийг даган баригч судар хэмээх 5 өөр номоос бүрддэг

						<p>2.Банзрагч судар. Орч.Л.Алтангэрэл. УБ., 2019. 324х.</p> <p>3.Дамдинсүрэн Ц. Монголын уран зохиолын дээж зуун билиг оршив. УБ., 2012. 272х.</p> <p>4.Сэржээ Ж. 1345 онд модон бараар хэвлэсэн Монгол Банзрагч судар олдов // Номын санч.- 2004.- №1.- Х.9.</p>	<p>тул Таван сахьяан буюу Таван сахиус хэмээн нэрлэдэг.</p> <p>Банзрагч судрыг Эсэнтөмөр хааны үед буюу 1324-1328 онд Шаравсэнгэ орчуулжээ. Судрын 5-р бүлгийн төгсгөл дэх 55 бадаг бүхий шүлэгт "... урьд мэргэд бандида нарын үнэн төгс туулсан энэ Банзрагч номыг олон амьтны тусын тулд бичүүлж үргэлж уншсанаар ад тотгор нь арилтугай. Борогчин тахиа жилийн арван сарын шинийн нэгэнд сударлаж төгсгөвэй." хэмээн бичсэнээс үүдэн 1345 онд Тогоонтөмөр хааны зарлигаар модон бараар хэвлэжээ хэмээн судлаачид үздэг.</p> <p>МУҮНС-д хадгалагдаж буй Банзрагч хэмээх их хөлгөн судар бол 1324-1328 оны үед монгол хэлнээ орчуулагдаж, улмаар 1345 онд Тогоонтөмөр хааны зарлигаар модон бараар хэвлэгдсэн тэрхүү эх мөн учраас 2.1.1 дэх шалгуурыг хангаж буй юм.</p> <p>Мөн тус сурвалж нь XIV зууны эхэн үед хамаарах монгол бичгийн чухал үнэ цэнтэй дурсгал болохоос гадна Монгол утга зохиолын хэл хөгжин бүрэлдэхээс өмнө орчуулгын зохиолын хэл үүссэн нэгэн түүхэн баримт болж бидний үед уламжлагдан ирснээрээ 2.1.3 дахь шалгуурыг хангаж буй юм.</p> <p>Банзрагч судар нь хэдийгээр шашны утга агуулгатай зохиол боловч орчуулгын зохиолын хувьд ялангуяа дундад эртний монгол хэлний онцлогийг хадгалсан байдгийнхаа хувьд монгол хэл шинжлэлийн дурсгалд зүй ёсоор тооцогддог тул 2.1.2 болон 2.1.3 дахь шалгуурыг тус тус хангаж байна.</p>
5	Данжуурын гэрээ бичиг	24/59	1	12.5x27.5 см	1119ТНС00212	<p>1.Аким Г. Шунхан Данжуурыг Монголд залсан Жамьян гүн нарын гавьяа. Номын</p> <p>Судар бичгийн хүрээлэн 1921 онд байгуулагдсан цагаасаа эхлэн ховор хуучин ном судрыг цуглуулах их үйлс эхлүүлсэн бөгөөд тэр үед цуглуулсан ховор ном судрын нэг нь "Монгол шунхан Данжуур" хэмээх их хөлгөн судар билээ.</p>	

						<p>санч. 2021 оны 11 сар. 14-17х.</p> <p>2.Өвгөн Дэндэвийн дурдатгал. УБ., ШУА-ийн хэвлэх үйлдвэр. 1961. 42х.</p> <p>3. Дарамбазар Б. Ганжуур Данжуур шинжлэх ухааны бүтээл болох нь: // Улирал ба зохиолч.- 2017.- №03.- Х.6–10.</p> <p>4.Дарамбазар Б. Ганжуур Данжуур шинжлэх ухааны бүтээл болох нь: // Улирал ба зохиолч.- 2017.- №03.- Х.6–10.</p> <p>5. 20. Энхтөр Д. Ганжуур, Данжуурын тухай товч өгүүлэхэд // Номын санч.- 1990.- №1.- Х.43–45.</p> <p>6.Гансүх Ч. Гэрээ бичиг (Данжуурын) // Номын санч.- 2005.- №1.- Х.55-56.</p>	<p>Халхын Сайн ноён хан аймгийн сэцэн засаг хошой чин ван Наянтын Цахарын сүрэг хошууны Шашныг бадруулагч сүмд тахигдаж байсан тус судрыг Судар бичгийн хүрээлэнд үүрд хадгалах тухай Наянт вангаас сайд Жамьян гүн, Ширнэндамдин Эрдэнэ жонон жүн ван нартай 1924 оны 12-р сарын 28-наа 9 зүйл бүхий гэрээ бичгийг Бээжид байгуулсан байдаг. Тус гэрээг монгол, хятад хэлээр бичсэн бөгөөд эдүгээ эх хувиараа МУҮНС-д хадгалагдаж буй тул 2.1.1 дэх шалгуурыг хангаж буй юм. Өөрийн өмчлөлийн номыг бусдад шилжүүлэхдээ гэрээ байгуулж байсныг, тэрхүү номыг дутаах эсвэл урж гэмтээвэл буцаан авах заалтыг оруулж өгсөн тус гэрээ нь тэртээ 100 гаруй жилийн өмнө байгуулагдсан боловч чухамхүү өнөөгийн гэрээ байгуулах түвшинд хийгдсэн тул 2.1.2 болон 2.1.3 дахь шалгуурыг хангаж буй юм. Мөн Монгол үсгийн бүрэн Данжуур ном нэгэн ижийн өмчлөлийн маргаангүй байх тухайд тус гэрээний гуравдугаар зүйлд “Энэ Данжуур номыг үүрд Их хүрээний Ардыг гэгээрүүлэх яамны Судар бичгийн хүрээлэнд хичээнгүйлэн хураан тахиж огт бусад хүний дураар салгаж зээлж гадагш гаргаж үзэх ба бас бус газарт нүүлгэн хурааж үл болмуй” хэмээн заасан нь 2.1.4-т заасан шалгуурыг хангаж байна хэмээн үзэж байна.</p> <p>Ийнхүү 226 боть монгол шунхан Данжуур, Данжуурын гэрэлт хөшөө, гэрээ бичиг нь нэгэн иж бүрдэл бүхий бичиг соёлын үнэт дурсгал юм.</p>
6	Зүрхний толтын тайлбар	24/49	1 /26 хуудас/	Цаасны хэмжээ: 44.7x9.0 см	1119ТНС00222	1.Балданжапов П.Б. Jirüken-ü tolta-yin	Бидний үед уламжлан ирсэн хэл зүйн бичгүүдийн хамгийн эртний хэл зүйн бичиг болох Зүрхний толтын тайлбар үсгийн эндүүрлийн

<p>үсгийн эндүүрлийн харанхуйг арилгагч Огторгуйн маань хэмээх оршив</p>				<p>бичвэрийн хэмжээ: 39.6x7.1 см, зузаан 0.4 см, жин 105 гр.</p>		<p>tayilburi. Улан-Удэ: Бурятск. 1962. 136х. 2. Дууар. Üjümčoin danjindaγba kiged oγtaγui-yin mani//öbür mongyul-un neyigem- ün sinjilekü uqayan. 1987.№4. X.26-34 3. Төмөртогоо Д. XVIII зууны үеийн Алшагийн эрдэмтэн рабжамба Данзандагвын зохиосон <<Зүрхэн толтын тайлбар үсгийн эндүүрлийн харанхуйг арилгагч огторгуй маань>> хэмээх хэл зүйн бичиг // Монгол хэл шинжлэлийн түүхэн уламжлал ба онолын үндэс. Улаанбаатар: Улсын Хэвлэлийн газар, 1981. 162х. 4. Цэрэнсодном Д. Молом равжамба Данзандагвын <<Богд Чойжи-Одсэр бээр зохиосон Зүрхний толтын тайлбар үсгийн эндүүрлийн харанхуйг арилгагч Огторгуйн маань>> // Монгол хэл шинжлэлийн үнэт</p>	<p>харанхуйг арилгагч Огторгуйн маань хэмээх бүтээлийг Равжамба Данзандагва 1727 онд зохиожээ. Уг зохиол нь Алин цагт гарсан уг, Үсгийн ялгал, Махбодын ялгал хэмээх 3 үндсэн бүлэгтэй. Тэргүүн бүлэгт Монголд шашин дэлгэрсэн, бичиг үсэг үүсэн гарсан, хэл зүйн бичиг зохиосон түүхийг хураангуйлан өгүүлсэн бол 2-р бүлэгт монгол бичгийн үсгийн бүрэлдэхүүн, ангилал, эгшиг гийгүүлэгч үсгийн байрлал, нэрийн тийн ялгал зэрэг асуудлыг голлон өгүүлсэн байдаг. Харин 3-р бүлэгт монгол хэлний эгшиг гийгүүлэгч авиаг Энэтхэг, Хятадын ёсоор огторгуй, хий, гал, ус, шороо махбод гэж ангилаад тэдгээрийн хэлэгдэх байдлыг өгүүлэх эрхтний үйл ажиллагаатай холбон тайлбарласан байдаг. XVIII зууны нэрт эрдэмтэн равжамба Данзандагвын зохиосон уг хэл зүйн бичиг нь өнөөгийн бидний үед уламжлан ирсэн монгол хэл шинжлэлийн бүтээлүүдийн дотроос Чойжи- Одсэрийн зохиосон “Зүрхэн толт”-ыг тайлбарлан дэлгэрүүлсэн хамгийн эртний, хамгийн дэлгэрэнгүй тайлбар гэдгээрээ онцгой ач холбогдолтой тул 2.1.2 болон 2.1.3 дахь шалгуурыг хангаж байна. Уг бүтээл нь бидний үед уламжлагдан ирсэн хамгийн эртний хэл зүйн бичиг бөгөөд хойч хойчийн эрдэмтдийн зохиосон хэл зүйн бүтээлийн үндэс суурь болсоор ирсэн онцгой бүтээл юм.</p>
--	--	--	--	--	--	---	---

						дурсгалууд. Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2021. Х.55-94.	
7	Итгэл /зүү ороож оёсон/	24/55	1 /8 хуудас/	Цаасны хэмжээ: 20.5x8.4 см бичвэрийн хэмжээ: 16.2x5.8 см, зузаан 1.3 см, жин 115 гр.	1119ТНС00216	1.Судар бичгийн алтан сан.- УБ., 2013.- 102х. 2.Монгол Улсын Үндэсний Номын сангийн эрдэнэсийн сан.-УБ., 2017.-166х. 3.Үндэсний бичиг соёлын өв.-УБ., 2017.- 212х.	Торгон утсаар өнгө ялган зүү ороож оёх урлаг нь монголчуудын дунд ихэд дэлгэрсэн гайхамшигтай урлаг юм. Үүний нэгэн төлөөлөл бол XIX зууны сүүлчээр Түшээт хан аймгийн Ар долоон гөрөөчин овгийн уран хатгамалч Должин хэмээх эмэгтэйн урласан Итгэл судар юм. Итгэл судар нь хурал ном, аливаа уншлагын эхэнд уншдаг бурхны шашны гол сургаал, зорин хүсэх ерөөлийг нэгтгэн товчилсон залбирал билээ. Энэ нь 3 хэсгээс бүрдэх бөгөөд 1. Гурван эрдэнэ болон бурхан, ном, хуврагийн авралд итгэх; 2. Гэгээрэхүйд итгэх, хамаг амьтныг гэгээрэлд хөтлөх; 3. Хамаг амьтан зовлонгоос ангижрах ерөөл зэрэг багтдаг байна. Уран хатгамалч Должингийн урласан Итгэл хэмээх судар нь эх хувиараа буй тул 2.1.1 дэх шалгуурыг хангаж буй юм. Түүнчлэн номын үсгийг алтан саан утсаар нэг ч зангилаа гаргалгүйгээр хар даавуун дээр шар торгон утсаар зүү ороож, маш гоёмсогоор урласан байх ба судрын нэг нүүрийг даавууныхаа нэг талд хатгасан бөгөөд ийм хоёр нүүрийг ар талаар нь судрын нэгэн хуудас болгон нийлүүлж ирмэгийг улаан торгон утсаар хөвөрдөн урласан тул 2.1.2 болон 2.1.3 дахь шалгуурыг тус тус хангаж буй юм.
8	Жадамба /Энх- Амгалангий н/	24/28	1	Цаасны хэмжээ: 82.0x32.6 см бичвэрийн хэмжээ: 70.6x25.8 см,	1119ТНС00623	1.Судар бичгийн алтан сан.- УБ., 2013.- 102х. 2.Монгол Улсын Үндэсний Номын сангийн эрдэнэсийн сан.-УБ., 2017.-166х.	Жадамба хэмээх нь “Найман мянган шүлэгт” гэх утгатай төвөд үг бөгөөд билиг барамидын судар юм. Бурхан багш 80 нас сүүдэр зооглох хүртлээ 45 жил сургаал номлол айлдсан байдаг. Тэрхүү сургаал номлолыг хожим шавь нар нь нэгтгэж гурван их чуулган хийсэн. Гурван их чуулганаар

				зузаан 22.5 см, жин 26350 гр.		3.Үндэсний бичиг соёлын өв.-УБ., 2017.-212х.	<p>бурхан багшийн 45 жилийн турш айлдсан сургаал номлолыг эмхэтгээд эртний пали хэл дээр тэмдэглэж үлдээсэн байдаг. Тэрхүү сургаал номлолыг агуулга бүтцийн хувьд гурав ангилбал:</p> <p>-Винайн аймаг савын ном.</p> <p>-Судрын аймаг</p> <p>Билиг барамидын аймаг буюу яаж билгийн чанад хязгаарт хүрэх вэ, хэрхэн гэгээрэлд хүрэх вэ гэдэг тухай номлосон байдаг. Эдгээр гурвыг эртний пали хэлээр Гурван аймаг савын ном буюу Трипитака хэмээн нэрлэдэг байна. Уг Трипитака буюу Гурван аймаг савын номыг хожим төвөд хэлээр орчуулсныг Ганжуур хэмээн нэрлэдэг.</p> <p>Ганжуур судрын утгыг хураавал Юмын аймагт, Юмын аймгийн 16 ботийн утгыг хураавал Хорин мянгат гэх хөлгөн сударт, Хорин мянгатын утгыг хураавал Арван найман мянгат, Арван найман мянгатын утгыг хураавал Арван мянгат, Арван мянгатын утгыг хураах юм бол Жадамба буюу Найман мянгат сударт хураагддаг байна. Тиймээс Жадамба судрыг бурхан багшийн зарлиг сургаалын оройн чимэг хэмээн эрт үеэс нандигнаж ирсэн байдаг.</p> <p>Энэхүү судрыг Энх-Амгалан хааны үед (1662-1722 он) модон бараар хэвлэсэн бөгөөд Монгол Улсын Үндэсний Номын санд хадгалагдаж буй хамгийн том барын ном тул 2.1.2 болон 2.1.3 дахь шалгуурыг тус тус хангаж буй юм.</p>
9	Модон бар /монгол үсгийн/	24/95	65	Өргөн 18.3 см, урт 40.8 см, зузаан-2.5 см	1119ТНС00160	<p>1.Судар бичгийн алтан сан.- УБ., 2013.- 102х.</p> <p>2.Монгол Улсын Үндэсний Номын сангийн эрдэнэсийн сан.-УБ., 2017.-166х.</p>	<p>Монголчуудын уламжлалт хэвлэлийн технологи бол бар хэвлэл юм. Сийлмэл аргаар бар буюу хэв хийж ном хэвлэхийг барын хэвлэл гэнэ. Модон бар, зэс бар, чулуун бар зэргийг хэрэглэж байснаас хамгийн түгээмэл дэлгэрсэн нь модон барын арга юм.</p>

						<p>3.Үндэсний бичиг соёлын өв.-УБ., 2017.- 212х.</p> <p>4. Монгол Улсын Үндэсний Номын сан дахь монгол бичгийн өв.- УБ., 2024.- 220х.</p>	<p>Тус бар нь “Богд ламын зохиолын хувь зүйл нэгээс үүсгэн туурвиж шашны үүдийг нээгч хэмээгдэх оршвой” хэмээх номын модон бар бөгөөд Монголын сүүлчийн хаан VIII Богд Жавзандамба хутагтын зохиосон бүтээл гэдгээрээ онцлогтой юм. Түүний амаар айлдсаныг Дарамбазар бичсэн байна.</p> <p>Энэхүү бүтээл нь XX зууны эхэн үеийн ороо бусгаа байдлыг дурдсан нэлээд сонирхол татахуйц бүтээлүүдийн нэгд тооцогддог юм. Түүнчлэн Богд хааныг хаан ширээнд хаана залсан, тухайн үед цагийн байдал ямар байсан зэргийн тухай ч өгүүлсэн байдаг бөгөөд модон бар нь харьцангуй бүрэн бүтнээрээ бидний үед уламжилж ирсэн бөгөөд хус модон дээр номын хоёр нүүрийг 2 багана болгон 24 мөрөөр сийлсэн байдаг. Уг модон барыг Ганданшаддүвлин хийдэд бүтээсэн бөгөөд Богдын Эх дагинын аймагт хадгалагдаж байжээ.</p>
10	Ү.Ядамсүрэн “Чойжи-Одсэрийн хөрөг зураг”	МҮН.201 3.1.1	1	Өндөр 60 см, өргөн 48.0 см	1119ТНС00635	<p>1.Соноцэрэн Л. Уран зураач Ү.Ядамсүрэн. УБ., Улсын хэвлэлийн газар. 1970. 20х.</p>	<p>Ардын зураач Ү.Ядамсүрэн ЗХУ-д Дорно дахины хөдөлмөрчдийн коммунист дээд сургуульд суралцан төгсөж ирээд Судар бичгийн хүрээлэнгийн харьяа Түүх, хувьсгалын музейд зураачаар ажиллаж том бага хэмжээний 80 гаруй хөрөг, суурь зураг 7, угсаатны зүйн сэдэвт бүтээл 200 гаруйг зурснаас хөрөг зураг зонхилох байрыг эзэлдэг байна. Тэрбээр 1959 онд “Чойжи-Одсэрийн хөрөг зураг”-ийг монгол зургийн аргаар зуржээ.</p> <p>Хөрөг зургийн их мастер хэмээн нэрлэгддэг Ү.Ядамсүрэн аливаа хөргийг зурахдаа уйгагүй судалгаа хийж бүтээлээ туурвидаг байна.</p> <p>“Чойжи-Одсэрийн хөрөг зураг” нь зүмбэрлэсэн хээ бүхий бор өнгийн модон жаазтай. Түүний хөргийг улаан өнгийн урт дээл, монгол гутал өмсөн оюу, номин шигтгээ бүхий бүс бүсэлж бийр, янтай,</p>

							<p>хуй унжуулж, баруун гартаа бийр барин доош хандуулан зүүн гартаа хуучин монгол бичгээр бичсэн хөх өнгийн хавтастай дэвтэрчилсэн номыг дэлгэн барьж хээ бүхий хүрэн өнгийн номын ширээний ард үл ялиг мишээн суусан байдалтайгаар дүрсэлжээ.</p> <p>Зургийн баруун доод буланд зураач өөрийн гарын үсэг болон бүтээсэн оныг монгол бичгээр бичсэн байдаг.</p> <p>Монгол Улсын Үндэсний Номын санд хадгалагдаж буй Ардын зураач Ү.Ядамсүрэнгийн зурсан “Чойжи-Одсэрийн хөрөг зураг” бол цорын ганц хувь бөгөөд эх хувиараа буй хосгүй өв тул 2.1.1, 2.1.2, 2.1.3 дахь шалгууруудыг тус тус хангаж буй юм.</p>
11	Ү.Ядамсүрэн “Эрдэмтэн Пагвагийн хөрөг зураг”	МҮН.201 3.1.2	1	Өндөр 59.6 см, өргөн 48.0 см.	1119ТНС00636	1.Соноцэрэн Л. Уран зураач Ү.Ядамсүрэн. УБ., Улсын хэвлэлийн газар. 1970. 20х.	<p>Ардын зураач Ү.Ядамсүрэн ЗХУ-д Дорно дахины хөдөлмөрчдийн коммунист дээд сургуульд суралцан төгсөж ирээд Судар бичгийн хүрээлэнгийн харьяа Түүх, хувьсгалын музейд зураачаар ажиллаж том бага хэмжээний 80 гаруй хөрөг, суурь зураг 7, угсаатны зүйн сэдэвт бүтээл 200 гаруйг зурснаас хөрөг зураг зонхилох байрыг эзэлдэг байна. Тэрбээр 1959 онд “Эрдэмтэн Пагвагийн хөрөг зураг”-ийг монгол зургийн аргаар зуржээ.</p> <p>Хөрөг зургийн их мастер Ү.Ядамсүрэн аливаа хөргийг зурахдаа уйгагүй судалгаа хийж бүтээлээ туурвидаг байжээ.</p> <p>“Эрдэмтэн Пагвагийн хөрөг зураг” нь зүмбэрлэсэн хээ бүхий бор өнгийн модон жаазтай. Ардын зураач Ү.Ядамсүрэн гуай нэлээд олон түүхэн хүмүүсийн хөргийг зурснаас Эрдэмтэн Пагвагийн хөргийг цайвар цэнхэр өнгийн уужтай, ногоон эмжээр бүхий улаан өнгийн ташуу энгэртэй дээл өмсөн, шар бүс бүсэлж ногоон өнгийн монгол гутал өмсөж баруун гараа доош хандуулан зүүн</p>

							<p>гартаа судар барьж үүлэн хээ бүхий шар өнгийн түшлэгт олбог дээр хагас завилгаагаар заларсан байдалтайгаар дүрсэлжээ.</p> <p>Зургийн баруун доод буланд зураач өөрийн гарын үсэг болон бүтээсэн оныг монгол бичгээр бичсэн байдаг.</p> <p>Монгол Улсын Үндэсний Номын санд хадгалагдаж буй Ардын зураач Ү.Ядамсүрэнгийн зурсан “Эрдэмтэн Пагвагийн хөрөг зураг” бол цорын ганц хувь бөгөөд эх хувиараа буй хосгүй өв тул 2.1.1, 2.1.2, 2.1.3 дахь шалгууруудыг тус тус хангаж буй юм.</p>
12	Ү.Ядамсүрэн “Зая бандида Намхайжамцын хөрөг зураг”	МҮН.201 3.1.3	1	Өндөр 59.5 см, өргөн 48.2 см.	1119ТНС00637	1.Соноцэрэн Л.Уран зураач Ү.Ядамсүрэн. УБ., Улсын хэвлэлийн газар. 1970. 20х.	<p>Ардын зураач Ү.Ядамсүрэн ЗХУ-д Дорно дахины хөдөлмөрчдийн коммунист дээд сургуульд суралцан төгсөж ирээд Судар бичгийн хүрээлэнгийн харьяа Түүх, хувьсгалын музейд зураачаар ажиллаж том бага хэмжээний 80 гаруй хөрөг, суурь зураг 7, угсаатны зүйн сэдэвт бүтээл 200 гаруйг зурснаас хөрөг зураг зонхилох байрыг эзэлдэг байна. Тэрбээр 1959 онд “Зая бандида Намхайжамцын хөрөг зураг”-ийг монгол зургийн аргаар зуржээ.</p> <p>“Зая бандида Намхайжамцын хөрөг зураг” бол зүмбэрлэсэн хээ бүхий бор өнгийн модон жаазтай. . Ардын зураач Ү.Ядамсүрэн гуай нэлээд олон түүхэн хүмүүсийн хөргийг зурснаас Зая бандида Намхайжамцын хөргийг шар эмжээртэй, ташуу энгэртэй улаан өнгийн дээл өмссөн, баруун гараар улаан өнгийн гоёмсог бичгийн ширээг тохойлдон, хоёр гартаа тод үсгээр бичсэн судрыг барин уншиж, амьтны арьсан дээр олбог дээр бохирч суусан байдалтайгаар дүрсэлсэн байна.</p> <p>Ойрадын Зая бандида Намхайжамцын хөргийг зурахад урьд өмнө нь Намхайжамцын ямар ч дүр мэдэгдээгүй байсан бөгөөд зураач судалгаа</p>

							<p>хийж, эцэст нь нимгэн царайтай, даруу харцтай, баруун монгол лам хүний дээл өмссөн хөрөг зурсан байдаг. Уг хөргийг зурсны дараа Намхайжамцын баримал дүр олдсон бөгөөд түүнийг Ү.Ядамсүрэн гуайн зурсан зурагтай жишиж үзэхэд их адилхан болсон гэлцдэг байсан бөгөөд энэ нь түүнийг аливаа хөргийг зурахдаа уйгагүй судалгаа хийж бүтээлээ туурвидаг байсныг илтгэнэ.</p> <p>Зургийн баруун доод буланд зураач өөрийн гарын үсэг болон бүтээсэн оныг монгол бичгээр бичсэн.</p> <p>Монгол Улсын Үндэсний Номын санд хадгалагдаж буй Ардын зураач Ү.Ядамсүрэнгийн зурсан “Зая бандида Намхайжамцын хөрөг зураг” бол цорын ганц хувь бөгөөд эх хувиараа буй хосгүй өв тул 2.1.1, 2.1.2, 2.1.3 дахь шалгууруудыг тус тус хангаж буй юм.</p>
13	Ү.Ядамсүрэн “Сажа бандида Гунгаажалцангийн хөрөг зураг”	МҮН.201 3.1.4	1	Өндөр 60 см, Өргөн 56.5 см.	1119ТНС00638	1.Соноцэрэн Л. Уран зураач Ү.Ядамсүрэн. УБ., Улсын хэвлэлийн газар. 1970. 20х.	<p>Ардын зураач Ү.Ядамсүрэн ЗХУ-д Дорно дахины хөдөлмөрчдийн коммунист дээд сургуульд суралцан төгсөж ирээд Судар бичгийн хүрээлэнгийн харьяа Түүх, хувьсгалын музейд зураачаар ажиллаж том бага хэмжээний 80 гаруй хөрөг, суурь зураг 7, угсаатны зүйн сэдэвт бүтээл 200 гаруйг зурснаас хөрөг зураг зонхилох байрыг эзэлдэг байна. Тэрбээр 1970 онд “Сажа бандида Гунгаажалцангийн хөрөг зураг”-ийг монгол зургийн аргаар зуржээ.</p> <p>Хөрөг зургийн их мастер Ү.Ядамсүрэн аливаа хөргийг зурахдаа уйгагүй судалгаа хийж бүтээлээ туурвидаг байжээ.</p> <p>“Сажа бандида Гунгаажалцангийн хөрөг зураг” нь хүрэн өнгийн хээ бүхий цагаан өнгийн жаазтай. Ардын зураач Ү.Ядамсүрэн гуай нэлээд олон түүхэн хүмүүсийн хөргийг зурснаас хүрэн өнгийн бандида малгай өмссөн, ногоон эмжээртэй, ташуу</p>

							<p>захтай, улбар шар өнгийн дээл өмссөн, шар үс бүсэлсэн, улаан орхимж нөмрөн, улаан хүрэн таншин өмсөн, баруун гараа энгэр тус газраа аван, зүүн гараа нотлох мутарлага үйлдэн, шар өнгийн түшлэгт олбог дээр завилан өмнөө буй гоёмсог бичгийн ширээнээ судар тавин залбирч буйгаар дүрсэлжээ.</p> <p>Зургийн баруун доод буланд зураач өөрийн гарын үсэг болон бүтээсэн оныг монгол бичгээр бичсэн байдаг.</p> <p>Монгол Улсын Үндэсний Номын санд хадгалагдаж буй Ардын зураач Ү.Ядамсүрэнгийн зурсан “Сажа бандида Гунгаажалцангийн хөрөг зураг” бол цорын ганц хувь бөгөөд эх хувиараа буй хосгүй өв тул 2.1.1, 2.1.2, 2.1.3 дахь шалгууруудыг тус тус хангаж буй юм.</p>
14	Ү.Ядамсүрэн “Өндөр гэгээн Занабазарын хөрөг зураг”	МҮН.201 3.1.5	1	Өндөр 61.5 см, өргөн 49.4 см.	1119ТНС00639	1.Соноцэрэн Л. Уран зураач Ү.Ядамсүрэн. УБ., Улсын хэвлэлийн газар. 1970. 20х.	<p>Ардын зураач Ү.Ядамсүрэн ЗХУ-д Дорно дахины хөдөлмөрчдийн коммунист дээд сургуульд суралцан төгсөж ирээд Судар бичгийн хүрээлэнгийн харьяа Түүх, хувьсгалын музейд зураачаар ажиллаж том бага хэмжээний 80 гаруй хөрөг, суурь зураг 7, угсаатны зүйн сэдэвт бүтээл 200 гаруйг зурснаас хөрөг зураг зонхилох байрыг эзэлдэг байна. Тэрбээр 1970 онд “Өндөр гэгээн Занабазарын хөрөг зураг”-ийг монгол зургийн аргаар зуржээ.</p> <p>Хөрөг зургийн их мастер Ү.Ядамсүрэн аливаа хөргийг зурахдаа уйгагүй судалгаа хийж бүтээлээ туурвидаг байсан бөгөөд уг хөргийн тухайд Өндөр гэгээн Занабазарыг соёмбо үсгийг зохиосон хэмээх утгыг онцлон соёмбо үсгийн бичвэрийг мөн зурсан байна.</p> <p>“Өндөр гэгээн Занабазарын хөрөг зураг” нь хүрэн өнгийн хээ бүхий цагаан өнгийн жаазтай. Ардын зураач Ү.Ядамсүрэн гуай нэлээд олон</p>

							<p>түүхэн хүмүүсийн хөргийг зурснаас Өндөр гэгээн Занабазарыг шар эмжээртэй, ташуу энгэртэй, цэнхэр нударгатай, шар өнгийн дээл өмссөн, улаан орхимж нөмрөн, баруун гартаа бийр барин цээжин тус газраа аван, зүүн гартаа соёмбо үсэг бүхий судрын хуудас дэлгэн /хүрэн өнгийн гоёмсог хээтэй бичгийн ширээн дээр/ түшлэгт олбог дээр завилан сууж бичиж буйгаар дүрсэлжээ.</p> <p>Зургийн баруун доод буланд зураач өөрийн гарын үсэг болон бүтээсэн оныг монгол бичгээр бичсэн байдаг.</p> <p>Монгол Улсын Үндэсний Номын санд хадгалагдаж буй Ардын зураач Ү.Ядамсүрэнгийн зурсан “Өндөр гэгээн Занабазарын хөрөг зураг” бол цорын ганц хувь бөгөөд эх хувиараа буй хосгүй өв тул 2.1.1, 2.1.2, 2.1.3 дахь шалгууруудыг тус тус хангаж буй юм.</p>
15	Ү.Ядамсүрэн “Гүүш Аюушийн хөрөг зураг”	МҮН.201 3.1.6	1	Өндөр 59.8 см, өргөн 48.0 см.	1119ТНС00640	1.Соноцэрэн Л. Уран зураач Ү.Ядамсүрэн. УБ., Улсын хэвлэлийн газар. 1970. 20х.	<p>Ардын зураач Ү.Ядамсүрэн ЗХУ-д Дорно дахины хөдөлмөрчдийн коммунист дээд сургуульд суралцан төгсөж ирээд Судар бичгийн хүрээлэнгийн харьяа Түүх, хувьсгалын музейд зураачаар ажиллаж том бага хэмжээний 80 гаруй хөрөг, суурь зураг 7, угсаатны зүйн сэдэвт бүтээл 200 гаруйг зурснаас хөрөг зураг зонхилох байрыг эзэлдэг байна. Тэрбээр 1959 онд “Гүүш Аюушийн хөрөг зураг”-ийг монгол зургийн аргаар зуржээ.</p> <p>Хөрөг зургийн их мастер Ү.Ядамсүрэн аливаа хөргийг зурахдаа уйгагүй судалгаа хийж бүтээлээ туурвидаг байжээ.</p> <p>“Гүүш Аюушийн хөрөг зураг” нь зүмбэрлэсэн хээ бүхий бор өнгийн модон жаазтай. Ардын зураач Ү.Ядамсүрэн гуай нэлээд олон түүхэн хүмүүсийн хөргийг зурснаас Эрдэмтэн Гүүш Аюушийн хөргийг сампин зангидсан шар орой бүхий хар малгай өмссөн, дугуй хээтэй шар өнгийн ташуу энгэртэй</p>

							<p>дээл, үүлэн хээтэй цайвар шар өнгийн ууж өмссөн, шар бүс бүслэн буриад гутал өмсөж, баруун гараараа хээтэй хүрэн өнгийн ширээ тохойлдон, зүүн гараа зүүн өвдөг дээрээ тавьж модон орон дээр сууж буйгаар дүрсэлжээ.</p> <p>Зургийн баруун доод буланд зураач өөрийн гарын үсэг болон бүтээсэн оныг монгол бичгээр бичсэн байдаг.</p> <p>Монгол Улсын Үндэсний Номын санд хадгалагдаж буй Ардын зураач Ү.Ядамсүрэнгийн зурсан “Гүүш Аюушийн хөрөг зураг” бол цорын ганц хувь бөгөөд эх хувиараа буй хосгүй өв тул 2.1.1, 2.1.2, 2.1.3 дахь шалгууруудыг тус тус хангаж буй юм.</p>
16	Ү.Ядамсүрэн “О.Жамьян гүний хөрөг зураг”	МҮН.201 3.1.7	1	Өндөр 80.0 см, өргөн 59.7 см.	1119ТНС00641	1.Соноцэрэн Л.Уран зураач Ү.Ядамсүрэн. УБ., Улсын хэвлэлийн газар. 1970. 20х.	<p>Ардын зураач Ү.Ядамсүрэн ЗХУ-д Дорно дахины хөдөлмөрчдийн коммунист дээд сургуульд суралцан төгсөж ирээд Судар бичгийн хүрээлэнгийн харьяа Түүх, хувьсгалын музейд зураачаар ажиллаж том бага хэмжээний 80 гаруй хөрөг, суурь зураг 7, угсаатны зүйн сэдэвт бүтээл 200 гаруйг зурснаас хөрөг зураг зонхилох байрыг эзэлдэг байна. Тэрбээр 1964 онд “О.Жамьян гүний хөрөг зураг”-ийг монгол зургийн аргаар зуржээ.</p> <p>Хөрөг зургийн их мастер Ү.Ядамсүрэн аливаа хөргийг зурахдаа уйгагүй судалгаа хийж бүтээлээ туурвидаг байжээ.</p> <p>Ү.Ядамсүрэн гуай аливаа хөргийг зурахын өмнө нарийн судалгаа хийдэг байсан нь О.Жамьян гуайн хөргөөс илэрхий харагдана. Учир нь О.Жамьян гуай тухайн цаг үедээ тэргүүн зэргийн сампинчны нэг байсан тул түүнийг тодруулахын тулд хөргийг сампинтай зурсан байна. Жамьян гуайн хөргийг Монгол Улсын Үндэсний Номын санд хадгалагдаж буй бусад хөргүүдтэй харьцуулахад монгол ахуй, амьдралыг илүү их шингээж өгснөөрөө онцлогтой байна.</p>

						<p>“О.Жамьян гүний хөрөг зураг” нь шар боронзон өнгийн модон жаазтай. Ардын зураач Ү.Ядамсүрэн гуай нэлээд олон түүхэн хүмүүсийн хөргийг зурснаас О.Жамьян гүний хөргийг хар эмжээртэй, луун дугуй хээтэй цэнхэр өнгийн амьтны үсэн нударгатай хурган дотортой дээл өмсөн, ногоон шаргал дурдан бүсэндээ хөөрөгний даалин хавчуулсан, хагас завилан сууж баруун өвдөг дээр бичгийн тавиур тавин баруун гартаа бийр барин, зүүн гараараа барьсан муутуу цаасан дээр монгол бичгээр бичин олбогт сууж буйгаар дүрсэлжээ.</p> <p>Зургийн баруун доод буланд зураач өөрийн гарын үсэг болон бүтээсэн оныг шинэ үсгээр бичсэн байдаг.</p> <p>Монгол Улсын Үндэсний Номын санд хадгалагдаж буй Ардын зураач Ү.Ядамсүрэнгийн зурсан “О.Жамьян гүний хөрөг зураг” бол цорын ганц хувь бөгөөд эх хувиараа буй хосгүй өв тул 2.1.1, 2.1.2, 2.1.3 дахь шалгууруудыг тус тус хангаж буй юм.</p>
НИЙТ 16 ДЭСИЙН 193 ШИРХЭГ						